

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САХИУЛАХАД МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХИЛ ДЭЭР ГАРЧ БУЙ ХИЛИЙН ЗӨРЧИЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

BORDER VIOLATION INFLUENCES BETWEEN MONGOLIA AND RUSSIA ON MAINTAINING BORDER SAFETY

**Ж.ӨВГӨНБҮРГЭД**

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн
Хил судлалын төвийн эрхлэгч, цэргийн ухааны доктор, дэд
профессор, хурандаа

UVGUNBURGED J.

Dean of Border studies center, Research and Development Institute, Ph.D,
colonel

Товч утга: Уг илтгэлд Монгол Улс, Оросын холбооны улсын хилийн гадаад, дотоод цагийн байдал, хилийн аюулгүй байдлыг сахиулахад хүчин төгөлдөр мөрдөж буй гэрээ, хэлэлцээр түүнийг боловсронгуй болгох арга замыг тодорхойлов. Мөн хоёр улсын хил дээр гарч буй хилийн зөрчлийн арга, хэлбэр түүнд нөлөөлж буй хүчин зүйл, хил хамгаалалтад орон нутгийн байгууллага, хил хамгаалахад туслах хүчний гишүүдын хүчин чармайлтыг тусгаж, цаашид хилийн аюулгүй байдлыг сахиулахад хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны талаар санал, зөвлөмжийг тусгав.

Abstract: The report is about Mongolian and Russian border's foreign and domestic circumstances of the time and agreements influencing factors for the border offences and identified ways to improve it. And the two countries border violence factors and form that have influenced him, border protection local authorities and reflects the efforts of members of the force to help protect the border, border security further discussed any recommendation on the cooperation of law enforcement agencies to maintain.

Түлхүүр үгс: Хилийн аюулгүй байдал, хууль эрх зүй, хилийн зөрчил, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэг, хил хамгаалалтад туслах хүчин.

Key words: Border security, law, border conflict, Organized crime groups, border protection force to help.

Өнөөдөр дэлхий нийтэд даяаршлын үйл явц гүнзгийрч, улс орнуудын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааны эргэлт тасралтгүй өсч байгаагийн зэрэгцээгээр үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хууль бус ажиллагаа улам нарийсч, үйл ажиллагаагаа нь нууц, далд хэлбэрээр явагдах болов. Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэг нь тухайн орны хууль, эрх зүйн хүрээнд гадуур хэд хэдэн орон дамнасан гэмт ажиллагаагаа явуулж, олсон санхүүгийн ашиг, орлогоо хил дамнуулан гаргадаг онцлогтой. Иймээс аливаа улс, үндэстэн аюулгүй байдлаа хангах үүднээс улсын хил хамгаалалт, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг улам төгөлдөржүүлэх, нягт хамтран ажиллах шаардлагатайг харуулж байна. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт Монгол Улсын язгуур эрх ашиг сонирхлыг гадаад, дотоодын аюул, заналаас хамгаалах, төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангахдаа хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, эрх зүйн хэм

хэмжээг сахих, хил залгаа улстай байгуулсан хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино. Харин хилийн аюулгүй байдлын үндсэн үүрэг нь газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хангах, хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчлүүлэхгүй байх, улсын хилийг зөрчилгүй байлгах, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, сайн хөршийн харилцааг бэхжүүлэх явдал юм.¹

Монгол Улсын умард хилд ОХУ-ын Бүгд Найрамдах Уулын Алтай, Тува, Буриад Улс, Эрхүү, Чита муж, орон нутгийн захиргааны 17 район хил залган оршиж байна. Монгол Улс умард хөрштэй албан ёсоор тогтоогдсон улсын хилийн шугамыг хоёр улсын Засгийн Газрын хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу харилцан тусалж, хамтын хүчээр шийдвэрлэх бүрэн эрхт хилийн төлөөлөгчийн газар ОХУ-ын Уулын Алтайн Акташ, Тувагийн Кызыл, Буриадын Хиагт, Мангут, Даурын хилийн отрядад ажиллаж байна.

Монгол Улс ОХУ-тай 1958, 1976 онд хоёр улсын хилийн гэрээ байгуулж, 1958-1960, 1976-1978 онуудад хилээ тогтоож, 1987-2000 онд нарийвчлан тодотгосны үр дүнд өнөөдөр Монгол Улс, ОХУ-ын хооронд 3453 км хилийн хэсэг албан ёсоор тогтоогдож үүнээс 2860 км хэсэг нь хуурай газраар, 683 км нь усан хилээр баталгаажсан. Үүнийг нарийвчлан үзвэл Алтайн Бүгд Найрамдах Улстай 298.4км, Тува 1348.9 км, Буриад 1029.6 км Чита мужтай 865.9 км хилийн хэсгээр зааглаж байгаа бөгөөд Монгол Улсын хилийн нийт шугамын 43 хувийг Монгол, ОХУ-ын хилийн хэсэг эзэлж байна. Энэхүү хилийн шугамд төрийн сүлд бүхий 1925 ш хилийн баганыг босгож, дунджаар нэг тэмдгээс нөгөө тэмдгийн хооронд 1.3 км ногдохоор нягтралыг бий болгон хил хамгаалалтыг зохион байгуулж байна.²

Өнөөдөр Монгол Улс, ОХУ-ын хооронд хилийн асуудлаар байгуулсан 15 гэрээ, хэлэлцээрийг байгуулан мөрдөж байгаа нь хилийн аюулгүй байдал, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд ихээхэн үр дүнтэй ажил болж байна. Үүнд: Монгол, Зөвлөлтийн хоорондох хилийн гэрээ [1958], Иргэн гэр бүлийн эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай [1988], ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай [1992], Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай [1993], Ургамал хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай [1993], Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай [1993], Гурван улсын хилийн уулзваруудын цэгийг тодорхойлох тухай [1994], Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай [1994], Хилийн усыг ашиглах тухай [1995], Иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай [1995], Агаарын харилцааны тухай [1997], Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх тухай [2000], Хилийн дэглэмийн тухай [2006] зэрэг Засгийн газрын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд багтаж байгаа бөгөөд энэхүү гэрээ хэлэлцээрийг мөрдөх, сахин биелүүлэхэд хил хамгаалах байгууллага болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа идэвхтэй явагдаж байгаагийн илрэл нь сүүлийн үед улсын хилд гарч буй хилийн зөрчил буурах, зохион байгуулалттай гэмт бүлгийн ажиллагааг цаг тухайд нь таслан зогсооход ихээхэн үр дүнгээ өгч байна.³

Энэ нь хоёр орны хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагаа бэхжиж байгаагийн илрэл бөгөөд зөвхөн энэ оны 5 дугаар сард ОХУ-ын Хилийн аюулгүй

¹ Хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа. УБ. 2012 он.

² Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал. УБ. 2012 он.


³ Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн жагсаалт. УБ. 2011 он

байдлын албаны захирлын орлогч, хилийн албаны удирдагч, армийн генерал В.Г.Кулишовын урилгаар ХХЕГ-ын дарга, хошууч генерал Ш.Лхачинжав айлчилсан бол 6 дугаар сард Монгол Улс, ОХУ-ын Сибирийн тойргийн хилийн удирдах газруудын бүс нутгийн уулзалтад ХХЕГ-ын штабын дарга, хилийн бүрэн эрхт төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй оролцож, хоёр орны хил хамгаалалт, бүс нутгийн хилийн аюулгүй байдлыг сахиулахад хамтран ярилцаж тохирсон.

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хилийн зөрчлийг бууруулах, таслан зогсоох зорилгоор улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хил хамгаалах байгууллагаас нэгдсэн бодлого, төлөвлөгөөг тасралтгүй хэрэгжүүлж байгаа боловч Монгол Улс, ОХУ-ын хил дээр гарч буй хилийн зөрчил нь ахуйн шинж чанараас зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгийн хэлбэрт шилжиж байгаа нь хил хамгаалалтад цэргийн, инженер техникийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн ажиллагаанаас гадна орчин үеийн техник, технологийн ололтыг өргөнөөр ашиглах, хамгаалалтын арга тактикийг боловсронгуй болгох шаардлага гарч байна.

Монгол Улс, ОХУ-ын хилийн хэсгээр өвс, эмийн ургамал түүх, байгалийн баялаг хулгайгаар ашиглах, ан агнах, мал хулгайлах, үгсэн хуйвалдаж хууль бусаар хориотой эд зүйл хил давуулах зэрэг хилийн зөрчил нь урьдаас төлөвлөсөн, санаатай үйл ажиллагаагаар идэвхжих болов. Хил дамнасан гэмт бүлгийн үйлдэл нь улсын хилийн дэглэм зөрчсөн хууль бус үйлдэл төдийгүй хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдалд халдсан ноцтой гэмт хэргийн шинжийг агуулдаг. Энэхүү гэмт үйлдэл нь гол төлөв зохион байгуулалттай хийгдэж, хоёр талын бүлгүүдийн тохиролцоонд үндэслэгдсэн, богино хугацаанд ашиг олох зорилготой тул илрүүлэх, таслан зогсооход хүндрэл учруулж байна.

Монгол Улсын хилд сүүлийн 5 жилд гарсан хилийн зөрчил



Монгол Улсын хилд гарч буй нийт зөрчлийн 79.6 хувь нь Монгол - Оросын хилд гарч байгаа бөгөөд үүнээс хилийн дэглэмийн зөрчил 79.6 хувь, хил орчмын дэглэмийн зөрчил 64.9 хувь, бэлчээрээр хил давсан малын зөрчил 87.3 хувь, улсын хилд тулсан малын зөрчил 42.8 хувийг тус тус эзэлж байна. Дээрх судалгаанаас дүгнэлт хийхэд зохион байгуулалттайгаар үйлдэгддэг малын хулгай, мансууруулах үйлчилгээтэй өвс, ургамал түүх, хулгайн ан хийх, бэлчээрээр мал хил давуулах зэрэг хилийн зөрчлүүд буурч байгаа нь харагдаж байна.

Монгол Улс хилийн аюулгүй байдлыг сахиулахад ихээхэн анхаарч, олон эрх зүйн акт гаргасны нэг нь “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, “Улсын

хил хамгаалалтад иргэдийг татан оролцуулах журам” зэрэг бичиг баримт юм. Энэхүү эрх зүйн актад улсын хил хамгаалалтад иргэн, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг хил хамгаалалтад оролцох эрх, үүрэг, ажиллах журмыг тусган өгч, тодорхой үе шаттай хэрэгжүүлж байна. Үүний илрэл нь 2015 онд Хил хамгаалах байгууллага, хил хамгаалахад туслах хүчний зөвлөл, гишүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Дорнод, Өмнөговь, Баян-Өлгий, Булган аймгуудын төвд бүсийн хэмжээнд Хил хамгаалах туслах хүчний гишүүдийн зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулав. Энэхүү зөвлөгөөнд хилийн 14 аймгийн 70 сумын 1400 туслах хүчний төлөөллөөс гадна аймгийн засаг дарга, иргэдийн хурлын дарга, тамгын хэлтэс, удирдах зөвлөлийн гишүүд оролцож, ололт амжилтаа дүгнэж, алдаа оноогоо харилцан зөвлөлдөж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөж, хил хамгаалалтад нэвтрүүлэх төсөл хөтөлбөрөө боловсруулж, эрх зүйн орчинг шинэчлэх, сургалт семинарыг зохион байгуулах талаар харилцан ярилцсан томоохон арга хэмжээ болж, түрүүчээсээ үр дүнгээ өгч байна. Монгол Улс, ОХУ-ын хилийн хэсэгт байрлах туслах хүчний судалгааг хүснэгтээр харуулав.⁴

Хилийн анги	Хилийн аймаг	Сумын ХХТХЗ-ийн тоо	Сумдын ХХТХЗ-ийн хэсгийн тоо	ХХТХГ		
				Нийт гишүүдийн тоо	Тогтмол оролцдог	Улирлын чанартай оролцдог
0165	Баян-Өлгий	5	4	220	120	100
0285	Баян-Өлгий	3	6	72	21	22
0311	Увс	3	14	108	54	16
0245	Увс	3	3	55	55	-
0277	Завхан	2	4	51	35	16
0257	Хөвсгөл	8	10	163	54	78
0286	Булган	2	4	60	19	27
0243	Сэлэнгэ	4	7	35	25	-
0101	Сэлэнгэ	2	2	40	40	-
0132	Дорнод	3	2	26	18	2
0275	Дорнод	4	5	24	24	-
0286	Хэнтий	3	5	32	18	-

Монгол Улсын умард хилийн Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймагт дунджаар 431.6 км, сумдад 95.9 км хилийн хэсэг ногдож байна. Эдгээрээс Дорнод аймгийн Эрээнцав, Халх гол, Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Сэлэнгэ аймгийн Түшиг, Сүхбаатар, Алтанбулаг зэрэг сум улсын хилд ойр байдгийг эс тооцвол ихэнх сумын төв нь улсын хилээс 20-260 км-ийн гүнд байрлаж байна. 2014 оны жилийн эцсийн дүн мэдээгээр умард хилийн хэсэгт байрлах аймаг, сумын туслах хүчний зөвлөлөөс улсын хил хамгаалалтад 34.3 сая төгрөгийн шууд хөрөнгө оруулалтыг хийснээс гадна харуулын болон дулаацах байр барих, хилийн хэсэгт өргөст утсан хашаа татах, бензин, түлшний мод бэлтгэж нийлүүлэх зэргээр төрөл бүрийн туслалцааг үзүүлж, харилцан ажиллаж байгааг дурдахад

⁴ Улсын хил хамгаалалтад орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоо зөвлөгөөн. УБ., 2014 он.

таатай байна. Тус бүс нутагт хилийн боомтын аюулгүй байдлыг сахиулах, улсын хилийг улс төр, дипломатын шугамаар хамгаалахад Хил хамгаалах байгууллагаас Баян-Өлгийн аймгийн Цагааннуур, Увсын Тэс, Давст, Завханы Тэс, Хөвсгөлийн Ханх, Сэлэнгийн Сүхбаатар хот, Алтанбулаг, Дорнодын Чулуун хороо, Баян-Уул сумдад хилийн 10 бүрэн эрх төлөөлөгч ажиллан үйл ажиллагаа амжилттай явуулж байна.

Өнөөдөр Монгол Улсын ОХУ-тай хиллэдэг хэсгийн хил хамгаалалтын нягтрал, газар орны онцлогийг харгалзан үзэхэд нэг талаас хилд ойр мэт байгаа боловч, бартаа саад ихтэй, хил зөрчигчийг эрэх, саатуулах ажиллагаанд байгалийн хүчин зүйл ихээр нөлөөлж, хүндрэл учруулж байгаа, нөгөө талаар улсын хил хамгаалалтад туслах хүч, орон нутгийн засаг захиргааны байгууллагыг татан оролцуулахад ихээхэн хүндрэлтэй байдаг. Иймд нэгдүгээрт хил хамгаалах байгууллага улсын хил хамгаалалтад техник, технологийн ололтыг ашиглах, хоёрдугаарт хил хамгаалалтын арга тактикаа боловсронгуй болгох, шаардлага дахин тавигдаж байна. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дараах хүчин зүйлийн нөлөөллийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- *Фикик, газар зүй, уур амьсгалын нөлөө*: Хилийн зарим хэсэгт байгаль, газар зүй, уур амьсгалын онцлогоос хамаарч, хамгаалалтгүй буюу хамгаалах боломж хязгаарлагдмал газар орны байдал,

- *Экологийн нөлөө*: Хил дамнасан ойн түймэр түүнээс үүдсэн байгалийн тогтоцод өөрчлөлт орох, ан амьтны шилжилт хөдөлгөөн, усталт, хилийн дагуух байгалийн баялаг ашиглагсдын хууль бус ажиллагаа,

- *Нийгэм, эдийн засаг, иргэдээс үүсэж болох нөлөө*: Хил орчмын нутаг дэвсгэр нь баялаг ихтэй, амьдрах орчин таатай тул хилийн зөрчлийн идэвхтэй ажиллагаа,

- *Хил, хязгаар нутгийн аюулгүй байдлын болзошгүй нөлөө*: Улсын хил дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйлдэл, дээрэм, хориотой ан хийх, хориглосон бараа хил нэвтрүүлэх ажиллагаа,

- *Сэтгэл зүйн нөлөө*: Хил дамнасан ойн түймэр, малын хулгай, гаалийн хүнд суртал зэрэг улсын хил хамгаалалтыг зохион байгуулахад хил залгаа улсын хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл, нээлттэй хилийн бодлого чухал байр суурь эзэлнэ.

Дүгнэлт, санал

Улс орны хэмжээнд үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд улсын хил дээр үүсэж болзошгүй будлиан, эмх замбараагүй байдал, гамшиг, ослын үед хилийн хамтарсан комисс байгуулан асуудлыг нэн даруй зохицуулах замаар хил, хязгаарын аюулгүй байдлыг хангах чиглэлийг стратегийн түвшинд хэрэгжүүлж ажиллана.

Бүс нутгийн түвшинд улсын хилийн бүсчилсэн хил хамгаалалтын хүрээнд зохион байгуулж, хилийн ус бохирдох, хүн, малын гоц халдварт өвчин гарах, хил зөрчигчийг эрэх, саатуулах үед хил залгаа улсын мэргэжлийн байгууллагууд хамтран хилийн төлөөлөгчийн шугамаар оперативын түвшинд хэрэгжүүлж ажиллана.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа нь олон улсын хөгжил, аюулгүй байдал, хүний эрхийг улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын нэг болж байна. Иймд хилийн аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагуудын хамтын

ажиллагааг бэхжүүлэхэд дараах санал, зөвлөмжид анхаарлаа хандуулна гэдэгт итгэж байна. Үүнд:

1. Увс, Тувагийн хилийн хэсгээр малын хулгай таслан зогсоогдохгүй байгааг харгалзан энэ чиглэлд хилийн инженерийн торон саад, төхөөрөмжийг иж бүрэн байгуулах, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх зорилгоор хилийн застав, харуулыг байгуулснаар хилийн зөрчил буурна гэж үзэж байна.

2. Улсын хил хамгаалалтад оролцож буй туслах хүчний гишүүд, дүйцүүлэх албаны иргэдийг "Хот айл", "Малчны нөхөрлөл"-ийн системд орон нутгийн удирдлага, малчидтай хамтран шийдвэрлэсэнээр хилийн манаа хүрэхэд хүндрэлтэй, хяналтад өртдөггүй газар орныг хяналтад авч, хил хамгаалалтад өдөр тутам үүрэг гүйцэтгэх нөхцөл бүрдэж, улмаар түүнийг тооцдог механизмыг хилийн хуульд оруулснаар иргэдийн идэвх дээшилж, хилийн зөрчлийг цаг тухайд илрүүлэх, таслан зогсоох нөхцөл бүрдэнэ.

3. Хил хамгаалах байгууллага хил дамнан орж ирсэн ойн түймэртэй тэмцэхэд гал унтраах техник, багаж хэрэгсэл дутагдалтай байдлыг харгалзан үзэж, онцгой байдлын газраас тусламж дэмжлэг үзүүлэх, улсын хил, хилийн боомт газар хүн, малын гоц халдварт өвчин үүссэн үед хамтран ажиллах эрх зүйн орчинг боловсронгуй болгосноор тулгамдаж буй асуудлыг тухай бүр нь шийдвэрлэх боломжтой.

4. Хил хамгаалах байгууллагаас улсын хил зөрчсөн, зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг саатуулсан үед тэднээс анхан шатны хэрэг бүрдүүлэлт хийх, байцаалт явуулах эрх зүйн орчинг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цаг хугацаа хэмнэх, хилийн зөрчлийг тухай бүр нь шийдвэрлэхэд ач холбогдолтой.

5. Хил зөрчигчийг илрүүлэх, зохион байгуулалттай гэмт бүлгийн ажиллагааны талаар үнэтэй мэдээлэл өгсөн, илрүүлэхэд туслалцаа үзүүлж нийгэмд учруулах хохирлоос урьдчилан сэргийлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнийг урамшуулах эрх зүйн орчинг хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар гарч буй хилийн зөрчил буурна гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт.

1. Хилийн тухай хууль. УБ. 1993 он
2. Дархан хил хөтөлбөр. УБ. 2007 он.
3. Монгол Улсын бүсчилсэн хил хамгаалалтын хөтөлбөр. УБ. 2011 он
4. Хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа. УБ. 2012 он.
5. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал. УБ. 2012 он.
6. Улсын хил хамгаалалтын түүхэн сургаж 80 жил. УБ. 2013 он
7. Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн жагсаалт. УБ. 2011 он
8. Ш. Лхачинжав. Улсын хил хамгаалалт ба иргэдийн оролцоо. УБ. 2010 он
9. Улсын хил хамгаалалтад орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоо зөвлөгөөн. УБ. 2014 он